ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шинэ эрин лаборатори сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2023/99/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2023 он | Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Энхдалай<br>Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn<br>Аудитор: Ч. Дашдаваа<br>Утас: 261628 Цахим хаяг: dashdavaach@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн :Баян ташаагийн эх Аудит ХХК<br>Захирал: Т.Хоролсүрэн<br>Утас: 99116028 Цахим хаяг: bte.audit@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.02.24 № 07/412

танай ____________-ны № ____________-т

ШИНЭ ЭРИН ЛАБОРАТОРИ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АМАРТҮВШИН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.4-д заасны дагуу Шинэ эрин лаборатори сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинэ эрин лаборатори сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 26,366.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8, 48 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д заасныг тус тус хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Шинэ эрин лаборатори сургууль нь Кембрижийн олон улсын хөтөлбөр болон үндэсний төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгаа шинжилгээ, туршилтын ажил хийх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Шинэ эрин лаборатори сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/491 дүгээр тушаалаар олгосон. Тусгай зөвшөөрөл нь 2023 оны 08 дугаар сарын 29-нийг хүртэл хүчинтэй байна.

Шинэ эрин лаборатори сургуулийн 15 бүлэгт 390 сурагч суралцдаг, Боловсрол шинжлэх ухааны яамнаас хийсэн Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ улсдаа 1 дүгээр түвшинд, сургалтын чанараар 2 дугаар байранд орсон, сурагчдын сурлагын амжилт 100 хувиар үнэлэгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Кембрижийн олон улсын хөтөлбөр болон үндэсний хөтөлбөрийн хичээл, сургалт, олон улсын шалгалтанд ашиглагдах химии, биологийн бодис, урвалж туршилтын багаж хэрэгсэл, материалуудыг хичээлийн үндсэн хэрэглэгдэхүүн болгон ашигладаг байна.

Тухайн хичээлийн жилд Камбрижийн олон улсын Checkpoint IGCSE, AS/A түвшний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчид цахимаар олон улсын шалгалтаа өгөх эрхээ авч төсөл амжилттай хэрэгжиж байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9096199
9019120396

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **47,387,752.40** | **52,229,015.14** |
| **33** | **АВЛАГА** | 21,000.00 | 96,600.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 96,600.00 |
| **335** | **Бусад авлага** | 21,000.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 21,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **47,366,752.40** | **52,132,415.14** |
| **351** | **Түүхий эд материал** | 17,201,333.74 | 30,172,293.74 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 17,201,333.74 | 30,172,293.74 |
| **354** | **Хангамжийн материал** | 30,165,418.66 | 21,960,121.40 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,062,745.00 | 2,143,940.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 22,062,601.00 | 14,992,401.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | 1,265,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 992,720.66 | 132,188.40 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 4,047,352.00 | 3,426,592.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,855,083,212.74** | **4,031,820,672.74** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **3,855,083,212.74** | **4,031,820,672.74** |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,835,633,847.99 | 4,010,325,272.73 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,750,560,295.00 | 3,750,560,295.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (200,922,873.12) | (267,897,164.16) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 20,000,000.00 | 10,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (9,999,999.96) | - |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 178,561,288.19 | 253,055,695.83 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (75,808,778.46) | (48,730,079.54) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 428,291,638.46 | 307,843,878.26 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (334,486,364.03) | (73,782,386.57) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,744,680.00 | 4,744,680.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (490,829.04) | (654,437.04) |
| 39217 | Ном | 75,184,790.95 | 75,184,790.95 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 19,449,364.75 | 21,495,400.01 |
| 39301 | Программ хангамж | 33,226,829.80 | 31,345,900.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (13,777,465.05) | (9,850,499.99) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,902,470,965.14** | **4,084,049,687.88** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **1,019,829.73** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 1,019,829.73 |
| **413** | **Өглөг** | - | 1,019,829.73 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 1,019,829.73 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,902,470,965.14** | **4,083,029,858.15** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,902,470,965.14 | 4,083,029,858.15 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 3,132,187,517.32 | 3,132,187,517.32 |
| 51101 | Өмч: - төрийн | 3,132,187,517.32 | 3,132,187,517.32 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (1,114,116,361.67) | (933,557,468.66) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (1,114,116,361.67) | (1,114,613,533.29) |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,529,121,389.00** | **1,947,445,155.50** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **95,090,189.00** | **312,005,355.50** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 16,775,900.00 | 22,075,110.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 78,314,289.00 | 289,930,245.50 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,434,031,200.00** | **1,635,439,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,433,031,200.00 | 1,635,439,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,433,031,200.00 | 1,635,439,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,000,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,583,510,229.92** | **1,757,757,290.87** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,583,510,229.92** | **1,757,757,290.87** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **951,015,552.68** | **1,116,291,561.58** |
| 210101 | Үндсэн цалин | 495,822,700.00 | 613,007,863.12 |
| 210102 | Нэмэгдэл | 327,776,932.60 | 396,435,888.21 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 41,415,120.08 | 56,492,750.00 |
| 210104 | Урамшуулал | 86,000,800.00 | 50,355,060.25 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **125,531,307.00** | **140,549,913.97** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 87,466,234.52 | 96,361,263.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,691,684.82 | 11,132,272.53 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,652,547.98 | 8,253,167.71 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,829,308.36 | 2,921,227.48 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,891,531.32 | 21,881,982.85 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **36,249,100.00** | **49,617,400.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,763,399.54 | 21,951,372.72 |
| 210302 | Түлш, халаалт | 15,576,000.46 | 21,822,927.28 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,909,700.00 | 5,843,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **37,852,777.34** | **43,463,841.95** |
| 210401 | Бичиг хэрэг | 8,580,712.00 | 5,137,585.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,467,294.50 | 6,414,042.26 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 17,816,514.84 | 16,129,386.69 |
| 210404 | Ном, хэвлэл | 72,600.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,915,656.00 | 15,782,828.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **899,000.00** | **169,450.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 169,450.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 899,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,826,700.00** | **21,970,320.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 715,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,826,700.00 | 21,255,320.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **114,363,210.35** | **99,166,492.69** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 109,576,510.35 | 91,375,692.69 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,000,000.00 | 1,200,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 131,900.00 | 110,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 54,800.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,600,000.00 | 6,446,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **183,862,510.58** | **184,812,119.38** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000,000.00 | 7,260,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 21,030,374.50 | 15,728,765.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 161,832,136.08 | 161,823,254.38 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **129,910,071.97** | **101,716,191.30** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 656,000.00 | 61,280,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 656,000.00 | 61,280,200.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **129,254,071.97** | **40,435,991.30** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 129,254,071.97 | 40,435,991.30 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | **(54,388,840.92)** | **189,687,864.63** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **51,439,217.40** | **8,631,800.00** |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 51,439,217.40 | 8,631,800.00 |
| **6** | **НИЙТ ҮР ДҮН** | **(105,828,058.32)** | **181,056,064.63** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Д.д | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **3,132,187,517.32** | **1,884,399,809.49** | **-1,008,309,303.35** | **4,008,278,023.46** |
| 2 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,132,187,517.32** | **1,884,399,809.49** | **-1,008,309,303.35** | 4,008,278,023.46 |
| 3 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -105,807,058.32 | -105,807,058.32 |
| 4 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,132,187,517.32** | **1,884,399,809.49** | **-1,114,116,361.67** | 3,902,470,965.14 |
| 5 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | -497,171.62 | -497,171.62 |
| 6 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,132,187,517.32** | **1,884,399,809.49** | **-1,114,613,533.29** | 3,901,973,793.52 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 181,056,064.63 | 181,056,064.63 |
| 8 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,132,187,517.32** | **1,884,399,809.49** | **-933,557,468.66** | 4,083,029,858.15 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,450,807,100.00** | **1,657,514,910.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **16,775,900.00** | **22,075,110.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 16,775,900.00 | 22,075,110.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 16,775,900.00 | 22,075,110.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 16,775,900.00 | 22,075,110.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,434,031,200.00** | **1,635,439,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,433,031,200.00 | 1,635,439,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,433,031,200.00 | 1,635,439,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,000,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,418,760,100.00** | **1,596,486,809.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,418,760,100.00** | **1,596,486,809.50** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,288,850,028.03 | 1,494,671,118.20 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **951,015,552.68** | **1,119,257,193.69** |
| 210101 | Үндсэн цалин | 495,822,700.00 | 590,477,200.00 |
| 210102 | Нэмэгдэл | 327,776,932.60 | 413,548,600.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 41,415,120.08 | 55,182,951.25 |
| 210104 | Урамшуулал | 86,000,800.00 | 60,048,442.44 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **125,531,307.00** | **137,244,052.13** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 87,466,234.52 | 94,441,935.72 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,691,684.82 | 10,858,855.18 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,652,547.98 | 8,626,723.95 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,829,308.36 | 2,126,540.46 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,891,531.32 | 21,189,996.82 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **36,249,100.00** | **49,617,400.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,763,399.54 | 21,951,372.72 |
| 210302 | Түлш, халаалт | 15,576,000.46 | 21,822,927.28 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,909,700.00 | 5,843,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **28,111,100.00** | **26,809,312.69** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,237,229.00 | 1,162,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,472,535.16 | 5,304,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 17,816,514.84 | 16,129,386.69 |
| 210404 | Ном, хэвлэл | 217,100.00 | 70,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,367,721.00 | 4,142,426.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **769,000.00** | **609,400.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 769,000.00 | 609,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 970,200.00 | 28,873,917.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 1,881,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 970,200.00 | 26,992,917.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **114,363,210.35** | **102,894,942.69** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 109,576,510.35 | 93,681,542.69 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,000,000.00 | 1,200,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 131,900.00 | 110,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 54,800.00 | 33,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,600,000.00 | 7,869,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **31,840,558.00** | **29,364,900.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000,000.00 | 7,260,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 30,840,558.00 | 22,104,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **129,910,071.97** | **101,815,691.30** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **656,000.00** | **61,379,700.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 656,000.00 | 61,379,700.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **129,254,071.97** | **40,435,991.30** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 129,254,071.97 | 40,435,991.30 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **32,047,000.00** | **61,028,100.50** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **32,047,000.00** | **61,028,100.50** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **32,047,000.00** | **61,028,100.50** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 32,047,000.00 | 61,028,100.50 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 32,047,000.00 | 61,028,100.50 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(32,047,000.00)** | **(61,028,100.50)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | (0.00) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,650,439,800.00** | **1,617,078,918.70** | **33,360,881.30** | **97.9** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,589,060,100.00** | **1,555,699,218.70** | **33,360,881.30** | **97.9** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,125,679,100.00** | **1,119,257,193.69** | **6,421,906.31** | **99.4** |
| 210101 | Үндсэн цалин | 590,477,200.00 | 590,477,200.00 | - | 100 |
| 210102 | Нэмэгдэл | 413,548,600.00 | 413,548,600.00 | - | 100 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 55,448,900.00 | 55,182,951.25 | 265,948.75 | 99.5 |
| 210104 | Урамшуулал | 66,204,400.00 | 60,048,442.44 | 6,155,957.56 | 90.7 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **137,753,000.00** | **137,244,052.13** | **508,947.87** | **99.6** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 102,381,900.00 | 94,441,935.72 | 7,939,964.28 | 92.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,842,800.00 | 10,858,855.18 | (2,016,055.18) | 122.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,074,200.00 | 8,626,723.95 | (1,552,523.95) | 121.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,768,500.00 | 2,126,540.46 | (358,040.46) | 120.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,685,600.00 | 21,189,996.82 | (3,504,396.82) | 119.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **49,617,400.00** | **49,617,400.00** | **-** | 100. |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,124,900.00 | 21,951,372.72 | (826,472.72) | 103.9 |
| 210302 | Түлш, халаалт | 22,649,400.00 | 21,822,927.28 | 826,472.72 | 96.4 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,843,100.00 | 5,843,100.00 | - | 100 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **26,811,900.00** | **26,809,312.69** | **2,587.31** | **100** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,335,700.00 | 1,162,900.00 | 172,800.00 | 87.1 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,346,200.00 | 5,304,100.00 | 42,100.00 | 99.2 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 16,128,400.00 | 16,129,386.69 | (986.69) | 100 |
| 210404 | Ном, хэвлэл | 171,500.00 | 70,500.00 | 101,000.00 | 41.1 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,830,100.00 | 4,142,426.00 | (312,326.00) | 108.2 |
| **2105** | **Нормативт зардал** | **609,400.00** | **609,400.00** | **-** | **100** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 609,400.00 | 609,400.00 | - | 100 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **78,593,700.00** | **78,586,617.50** | **7,082.50** | **100** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 51,593,700.00 | 51,593,700.50 | (0.50) | 100 |
| 210604 | Урсгал засвар | 27,000,000.00 | 26,992,917.00 | 7,083.00 | 100 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **136,881,000.00** | **110,480,842.69** | **26,400,157.31** | **77.4** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 119,268,600.00 | 93,681,542.69 | 25,587,057.31 | 68.6 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,000,000.00 | 1,200,000.00 | 800,000.00 | 60.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 110,900.00 | 110,900.00 | - | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 46,100.00 | 33,000.00 | 13,100.00 | 71.6 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 15,455,400.00 | 15,455,400.00 | - | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **33,114,600.00** | **33,094,400.00** | **20,200.00** | **99.9** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,280,300.00 | 7,260,100.00 | 20,200.00 | 99.7 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 25,834,300.00 | 25,834,300.00 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **61,379,700.00** | **61,379,700.00** | **-** | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **61,379,700.00** | **61,379,700.00** | **-** | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 61,379,700.00 | 61,379,700.00 | - | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,650,439,800.00** | **1,617,078,918,70** | **33,360,881,30** | **97,9** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,635,439,800.00** | **1,595,003,808,70** | **40,435,991,30** | 97,5 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 1,635,439,800.00 | 1,595,003,808.70 | 40,435,991,30 | 97,5 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **15,000,000.00** | **22,075,110.00** | **(7,075,110.00)** | **147.2** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,000,000.00 | 22,075,110.00 | (7,075,110.00) | 147.2 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - | **-** | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - | **-** | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 444 | 444 | | 100 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | | 100 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | | 100 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 53 | 53 | | 100 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | | 100 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 43 | 43 | | 100 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 9 | 9 | | 100 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 390 | 390 | | 100 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 390 | 390 | | 100 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 390 | 390 | | 100 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 52,562.9 мянган төгрөгийн алдаа илэрснээс 52,375.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 187.0 мянган төгрөгийн алдааг залруулаагүй тул алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.Үүнд:

Аудитаар нийт 29,324.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 4,247.8 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 13,199.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж 11,877.5 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 29,324.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 26,366.4 мянган төгрөгөөс өндөр байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ТШЗ | 2 | 52,562.9 | | | 2 | 52,562.9 | 1 | 52,375.6 | 1 | 187.0 | | |
| **Дүн** | **2** | **52,562.9** | | | **2** | **52,562.9** | **1** | **52,375.6** | **1** | **187.0** | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийн дансанд 6 нэр төрлийн 187.0 мянган төгрөгийн хангамжийн материал бүртгэсэн. | 1 | 187.0 | | | | | 1 | 187.0 | | | | |
| Саиборг ХХК-аас худалдан авсан Олон улсын шалгалтын хэрэглэгдэхүүний үнэ болох 115.1 мянган төгрөгийг давхардуулан олгосон | 1 | 115.1 | 1 | 115.1 | | | | | | | | |
| "County" маркийн автобусан шатахуун зарцуулалтын жишиг нормоос 405.2 мянган төгрөгийн дизель түлш хэтрүүлэн зарцуулсан байна. | 1 | 405.2 | 1 | 405.2 | | | | | | | | |
| Сургуулийн цайны газрыг эцэг эхийн зөвлөлийн мэдэл шилжүүлэн түрээсийн гэрээ байгуулаагүй ажиллуулсан байна | 1 | 3,727.5 | 1 | 3,727.5 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төлбөртэй ашиглуулах сурах бичгийн түрээсийн төлбөр болох 4,154.8 мянган төгрөгийг номын санч хувийн дансаараа хүлээн авсан. | 1 | 4,154.8 | | | | | 1 | 4,154.8 | | | | |
| Тайлант онд 10 ААН-ээс 7,535.7 мянган төгрөгийн хангамжийн материалыг НӨАТ-ын цахим төлбөрийн и-баримтгүй худалдаж авсан. | 1 | 7,535.7 | | | | | 1 | 7,535.7 | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу худалдан авалтыг зохион байгуулаагүй 13,199.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан | 1 | 13,199.6 | | | 1 | 13,199.6 | | | | | | |
| Дүн | 7 | 29,324.9 | 3 | 4,247.8 | 1 | 13, 199.6 | 3 | 11,877.5 | | | | |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | | | | | 1 | | |
| | **НИЙТ** | **1** | | | | | **1** | | |